

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№ 16/438

ШУС, НУС

2015

**ОЛОН УЛСЫН СЭДВИЙН БҮТЭЦ, АГУУЛГАД**  
**ХИЙСЭН СУДАЛГАА**

Л.Ариун \*

\* ХИС-ийн Сэтгүүл зүй, медиатехнологийн тэнхимийн багш, доктор (PhD), дэд профессор

**Түлхүүр үг:** олон улсын сэдэв, мэдээлэл дамжуулах аргачлал, мэдээллийн хөтөлбөр

**М**онголын хэвлэл мэдээллээр олон улсын сэдвийг хэрхэн тусгаж буйг тандах зорилгоор телевизийн гадаад мэдээний хөтөлбөр, өдөр тутмын сонины гадаад мэдээний нүүрт ажиглалт судалгаа хийлээ. Голлох судалгааг өдөр тутмын “Өнөөдөр”, “Өдрийн сонин”, МҮОНТВ, Ийгл, UBS телевизийн 1 сарын гадаад мэдээлэлд хийсэн болно. Дэлхийн улс орнуудын эдийн засгийн хамаарал өсөн нэмэгдэж, аливаа улсад өрнөсөн улс төр, эдийн засгийн чухал үйл явдал бусад улс оронд нөлөөлөх болжээ. Ийм учир гадаад орны мэдээ, мэдээллийн ач холбогдол, үүрэг, хүрээ өргөжиж байна. Дэлхий бөөрөнхий гэсэн ойлголт харилцаа холбоо, мэдээллийн хэрэгсэл, Интернет орчин нөхцлийн хил хязгаар тэлснээр өөрчлөгдөж, “дэлхий хавтгай” гэх ойлголт дэлгэрсэн энэ цаг үед зөвхөн дотоодын үйл явдлын мэдээлэл түгээхээс гадна гадаад ертөнцийн чухал үйл явдлыг үзэгч, уншигчдад шуурхай, олон талаас нь, тэнцвэртэй хүргэх нь гадаад мэдээний салбарт гол шалгуур болж байна. Манай хэвлэл мэдээллийн

хэрэгслүүд энэ үүргээ ерөнхий утгаараа биелүүлж байгаа ч мэдээлэл дамжуулах аргачлал, мэдээллийн нийт хөтөлбөрт агуулагдах олон улсын сэдвийн багтаамж, төрөл зүйл, агуулга хандлага, олон талт байдал зэрэг нь хүлээн авагчдын хэрэгцээ шаардлагад нийцэхэд учир дутагдалтай байгааг судлаачид тэмдэглэсээр байна.

Юуны өмнө тэмдэглэхэд манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүд “ХБНГУ-ын амьтны хүрээлэнгийн цагаан баавгайн бамбаруушнуудад нэр өгчээ”, “Фолклэндийн аралд санал хураалт явагдаж байна”, “Египетийн армийн командлагч Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөхөө албан ёсоор мэдэгджээ”, “Наоми Кэмпбэлл 100 мянган ам. доллар шуба авчээ” гэх зэрэг мэдээлэлд багагүй зай талбай, цаг хугацаагаа зарцуулсан хэвээр байна. Сүүлийн 5 жилд хийсэн судалгаагаар сонины ашигтай талбайн, телевизийн мэдээллийн хөтөлбөрийн 10 орчим хувийг олон улсын сэдэв эзэлсээр байна. Энэ нь тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын тогтсон бодлого, төлөвлөлттэй холбоотой.

Сэдвийн хувьд аваад үзэхэд айлчлал, мэдэгдэл, гэрээ хэлэлцээр зэрэг улс төрийн хүрээнд болсон үйл явдлын мэдээ жин татаж байгаа юм. Цаашлаад

осол аваар, аллага хүчирхийлэл, жагсаал цуглаан, оддын амьдрал, спорт, эрүүл мэнд гэх мэт цөөн хэдхэн сэдвийн хүрээнд бичиж байна. Сэдвээс хамаарч гадаад мэдээллийн дийлэнх нь сөрөг агуулгатай. Гэмт хэрэг, дайн тулаан, бослого хөдөлгөөн, жагсаал цуглаан гэхчилэн сөрөг мэдээллийг манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүд олон улсын мэдээллийн агентлагуудын мэдээллийн сүлжээгээс түүвэрлэн сонгож байгаа нь тогтсон үзэгдэл болчихоод байна. Түүнчлэн *“Перугийн зартай гэмт хэрэгтнүдийг баривчиллаа”*, *“АНУ-д 70 орчим настай иргэн нэг гэр бүлийг буудан хөнөөв”*, *“Египет улс 683 хүнд цаазын ял оноов”* зэрэг уншигчдад хамаарал, ач холбогдол төдийлөн байхгүй мэдээлэл олон улсын мэдээнд зориулсан багахан зай талбай, цагийг дүүргэж байгаа нь харамсалтай. Ер нь “манай гадаад мэдээ нийтлэл нэвтрүүлэг улс орны хөгжил дэвшлийн магтаал болоод байгаль ертөнцийн байдал, эсвэл дайн байлдаан хямрал зөрчил гэмт хэргийн сонин хачин болчихоод байгаа нь олон улсын сэтгүүл зүйн гажуудал гэхээр үзэгдэл билээ”<sup>1</sup> хэмээн доктор Б.Болд-Эрдэнэ 2005 онд тэмдэглэсэн ба өдгөө 10 жилийн дараа ч энэ байдал хэвээр байгаа нь анхаарал татаж байна.

Судалсан хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дотроос Ийгл телевиз болон “Өнөөдөр” сонин олон улсын үйл явдлын харьцангуй өргөн хүрээнд, ач холбогдолтой сэдвээр, бас бичлэгийн янз бүрийн төрөл ашиглан мэдээлж байсныг дурдах нь зүйтэй юм. Энэ удаагийн судалгаанд хамрагдаагүй ч сүүлийн үед “Монгол” телевиз гадаад мэдээллийн хөтөлбөрөө олон улсын харилцааны мэргэжилтэн, судлаачийг тогтмол урьж, цаг үеийн үйл явдал, үзэгдэлд тойм, тайлбар хийж яриулдаг

нь өгөөжтэй. Гадаадын агентлагуудын байр суурь, өнцгөөс харсан, эсвэл олон улсын мэдээлэл бэлтгэдэг орчуулагч, сэтгүүлчийн дүгнэлт бүхий мэдээллээс зайлсхийж дипломатч, судлаачдын олон талаас нь хандаж, даацтай үндэслэл, тайлбар хийсэн мэдээллийг хүргэх хэлбэр дутагдалтай байгааг сэтгүүл зүй судлаачид тэмдэглэсээр иржээ. Ийм туршлага манай сэтгүүл зүйд урьд өмнө нь байсан. Б.Дүгэр, Д.Базарваань, Ц.Даваажав зэрэг тоймчид олон улсын мэдээлэлд тайлбар хийж телевизийн мэдээллийн хөтөлбөр, сонины гадаад мэдээний буланд тогтмол гардаг байсныг хэвлэл мэдээллийн байгууллагууд сэргээн орчин үеийн олон улсын харилцааны мэргэжилтнүүдийг урьж томоохон үйл явдал, тулгамдсан асуудлыг монгол уншигчдад олон талаас нь тоймлож, тайлбарлаж хүргэх шаардлага юу юунаас илүү чухал байна. Доктор Б.Наранбаатар: «Дэлхий нийтийн даяар асуудал, цаг үеийн хурцадмал үйл явдлын талаарх мэдээллийг хэн нэгэн гадны эх сурвалжийг дагнан Монгол үндэстний сонирхол эрх ашиг үл “үнэртсэн” мэдээлэл уншигчлал хүрч буйг сонинууд анхааралдаа авах ёстой»<sup>2</sup> хэмээсэнтэй санал нэг байна.

**М**анай гадаад мэдээнд аль улсын тухай хамгийн их мэдээлдэг вэ хэмээн авч үзэхэд АНУ-тай холбоотой мэдээ мэдээлэл тэргүүлэх байрыг тогтмол эзэлж иржээ (тогтмол 20 орчим хувь). Энэ нь дийлэнх нь Холливудын оддын амьдрал, Б.Обамаг тойрсон үйл явдлууд гэсэн үндсэн хоёр хэсэгт л хуваагдана. Түүнээс эрүүл мэнд, экологи, шинжлэх ухаан технологи зэрэг сэдэв юм уу, Монголтой холбоотой, хэрэглэгчдэд ашиг болохуйц мэдээлэл байх нь ховор. Монголын хэвлэл

мэдээллийн хэрэгсэл нийгэмд гадаад соёлын нөлөөг хүчтэй дэлгэрүүлж байгааг судлаачид шүүмжлээд, чухам аль улсын соёлын нөлөөг их байгааг судлаад авч үзэхэд өрнөдийн соёлын түрэмгийлэл их байна<sup>3</sup> хэмээн дүгнэсэн нь бий. Солонгосын олон ангит кино, Японы сумо бөхийн барилдаан, Оросын олон ангит кино, баримтат кино, нэвтрүүлгүүд гээд төрөлжсөн хөтөлбөрүүд манай телевизийн хөтөлбөрт багагүй байх суурь эзэлж байгаа.

Тэгвэл Америкийн хувьд олон ангит кино, хүүхэлдэйн кино, спорт, урлаг гээд бүхий л төрлийн нэвтрүүлэг, нийтлэл гарч байгааг судалгаагаар илрүүлсэн байдаг. Энэ үзэгдэл олон улсын мэдээллийн сонголтод бас нөлөөлдөг байх талтай. Үнэхээр олон улсын мэдээллийн багагүй хувийг Аме-

рик киноны жүжигчид, алдартай дуучид, уран бүтээлчид, спортын одуудын амьдрал, уран бүтээл, тэдгээрийг тойрсон хов жив эзэлдэг нь сүүлийн жилүүдийн тогтсон судалгаагаар нотлогдсон юм.

Манай олон улсын мэдээлэл хязгаарлагдмал хэдхэн сэдвийн хүрээнд эргэлддэг бол дэлхийн улс орнуудыг хамруулсан байдлын хувьд эсрэгээрээ маш өргөн хүрээтэй байдаг аж. Судалгаа хийсэн 5 мэдээллийн хэрэгслийн нэг сарын гадаад мэдээлэлд 80 орчим улсын тухай дурджээ. (Нэг мэдээллийн хэрэгсэлд дунджаар 40 орчим орны тухай мэдээлжээ.) Олон жилийн туршлагатай UBS телевизийн

“City news” мэдээллийн хөтөлбөрийн дэлхийн мэдээнд геополитикийн хувьд Монгол улстай төдийлөн хамааралгүй улс орон олон байгаа бөгөөд ач холбогдол, үр нөлөө бага, сонирхуулах төдий л бэлтгэсэн мэдээ их гардаг. Жишээлбэл “*Николас Мадур*а цалингийн хэмжээг нэмэгдүүлэхээ амлав” гэсэн мэдээг авч үзвэл, монголчууд бид хэзээнээс венесуэлчүүдийн цалингийн хэмжээнд санаа зовдог болоо вэ гэж бодохоор байна. Гэвч энэ төрлийн

манайд хамааралгүй үйл явдлыг олон удаагийн давтамжтай нарийвчилан мэдээлэх нь түгээмэл ажээ.

Олон улсын мэдээллийн нэг чухал асуудал болох мэдээллийн үнэлэмжийг доктор Б. Болд-Эрдэнэ тодорхойлохдоо: “Тэргүүн зэргийн ач холбогдлын хүрээ нь нэгдүгээрт өм-

нөд, хойд хоёр том хөршийн, хоёрдугаарт эдийн засгийн нөлөө, дэмжлэг үзүүлэх улс орны, гуравдугаарт дэлхийн нийгмийн тулгамдсан, зөрчилт асуудал”<sup>4</sup> хэмээн ангилсан байдаг. Харин судлаач Б.Наранбаатар “Олон улсын мэдээ, мэдээллийн ач холбогдлын хүрээнд дэлхийн нийгмийн зөрчилт, тулгамдсан асуудал нэгдүгээрт тавих санал оруулж байна”<sup>5</sup> гэжээ. Сүүлийн 5 жилд бидний хийсэн ажиглалт судалгаагаар дэлхийн нийгмийн тулгамдсан асуудлын тухай мэдээ, мэдээлэл эзлэх хувь хэмжээгээрээ ямагт дээгүүр үзүүлэлттэй гарч байв. Дээрх үнэлэмжийн тухай ямар байр суурьтай байгааг тандах



*Монголтой холбоотой,  
хэрэглэгчдэд ашиг болохуйц  
мэдээлэл байх нь ховор. Монголын  
хэвлэл мэдээллийн хэрэгсэл  
нийгэмд гадаад соёлын нөлөөг  
хүчтэй дэлгэрүүлж байгааг  
судлаачид шүүмжлээд, чухам аль  
улсын соёлын нөлөөг их байгааг  
судлаад авч үзэхэд өрнөдийн  
соёлын түрэмгийлэл их байна  
хэмээн дүгнэсэн нь бий*



зорилгоор МҮОНТ, UBS, SBN, C1, NTV, TV5, TV9, 25-р суваг телевиз зэрэг 8 телевиз, “Өнөөдөр”, “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” зэрэг гурван сонин, “Тойм”, “Гэрэг” хоёр сэтгүүл, www.likenews.mn нэг сайтын нийт олон улсын мэдээний 14 редактораас санал асуулга авлаа. Олон улсын мэдээний редакторуудын 90 орчим хувь нь хоёр орны тухай мэдээллийг тэргүүн зэргийн ач холбогдолтой, түүнчлэн эдийн засгийн нөлөө бүхий улс орон, дэлхийн нийтийн тулгамдсан асуудал гэх мэтээр дараалуулсан нь доктор Б.Болд-Эрдэнийн үнэлэмжтэй санал нэг байгаагаар илэрхийлсэн байна. Гэсэн хэдий ч бодит байдал дээр хоёр хөршийн тухай мэдээлэл ямагт бага, дэлхийн нийгмийн тулгамдсан асуудлыг тэргүүн зэрэгт тавин мэдээлсээр байгаа нь харагдаж байна.

**Э**цэст нь тэмдэглэхэд хоёр хөршийн тухай мэдээлэл өнөөгийн бодит шаардлага, эрэлт хэрэгцээтэй харьцуулбал дэндүү бага, дэлхийн нэр хүндтэй олны танил хүмүүсийн тухай сонин хачин багагүй хувийг эзэлдэг байдлыг өөрчилж, дэлхийг харах, ойлгох, мэдэх, дүгнэх сэтгүүл зүй хэрэгтэй байгааг 10 жилийн өмнө сануулсан Б.Болд-Эрдэнэ докторын сануулгыг дахин сануулах шаардлага өнөө ч байна. Мөн олон улсын асуудлыг зөвхөн “сонирхуулах” зорилгоор бичиж, бусдын байр суурийг зөвхөн “импортлох” маягтай мэдээллийн урсгал тогтсоныг илрүүлсэн доктор Б.Наранбаатарын таван жилийн өмнө хийсэн судалгаа дүгнэлт өнөөдөр ч давтагдаж буйг хэвлэл мэдээллийн байгууллага, олон улсын мэдээний

сэтгүүлч, редакторууд, судлаачид ч анхаарах нь зүйтэй.

### Ишлэл

<sup>1</sup> *Болд-Эрдэнэ Б.* 2005. Шинэ цаг үе, шинэ хандлага, шинэ сэтгүүл зүй // “Сэтгүүл зүй” МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №5 (249), 20 дахь тал.

<sup>2</sup> *Наранбаатар Б.* Өдөр тутмын олон улсын мэдээ, мэдээлийн чанарыг дээшлүүлэх асуудалд // “Сэтгүүл зүй” МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №11 (337), 30 дахь тал.

<sup>3</sup> *Ариунзул Г.* 2015. Даяаршил уу далд империализм уу? // “Гэрэг” сэтгүүл, №66.

<sup>4</sup> *Болд-Эрдэнэ Б.* Дурд. зох., 20 дахь тал.

<sup>5</sup> *Наранбаатар Б.* Дурд. зох., 30 дахь тал.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Ариунзул Г.* 2015. Даяаршил уу далд империализм уу? // “Гэрэг” сэтгүүл, №66.

2. *Баярхүү Д.* 2007. Бид ингэхэд хэн юм бэ? УБ.

3. *Болд-Эрдэнэ Б.* 2005. Шинэ цаг үе, шинэ хандлага, шинэ сэтгүүл зүй // “Сэтгүүл зүй” МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №5 (249).

4. *Наранбаатар Б.* Өдөр тутмын олон улсын мэдээ, мэдээлийн чанарыг дээшлүүлэх асуудалд // “Сэтгүүл зүй” МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №11 (337).

5. *Норовсүрэн Л.* 2005. Олон улсын мэдээлэл дэх геополикийн зарим асуудалд // “Сэтгүүл зүй” МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №5 (249).

### Resume

In conclusion, there is a significant lack of information about the two neighbors relative to today's actual need. The scientists' warning that journalism needs to change from overly focusing on news about world celebrities to becoming more of a tool for understanding, knowing and reviewing the world situation is still effective.